



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА**

2018 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 14

Номгон

Г Зөрчил арилгуулах тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Жаргалант сумын Сум хөгжүүлэх сангийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сум хөгжүүлэх сангийн 9 зээлдэгчийн хугацаа хэтэрсэн зээл болох 49950401 төгрөгийг шүүхийн байгууллагад шилжүүлэх.

Энэ нь Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор баталсан "Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам"-ын 4.7-д " Иргэн хуулийн этгээд авсан зээл, зээлийн хүүг гэрээнд заасан хугацаанд сангийн дансанд төвлөрүүлнэ." гэсэн заалтыг зөрчсөн байна




Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.1.7-д "Хууль, тогтоомж зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх..." гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Сангаас олгосон хугацаа хэтэрсэн зээлүүдийн үлдэгдэл болох 49950401 /дөчин есөн сая есөн зуун тавин мянга дөрвөн зуун нэг / төгрөгийг хуулийн байгууллагаар шийдвэрлүүлэх.

2. Албан шаардлагын биелэлтийг 2018 оны 04 дугаар сарын 25-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Жаргалант сумын Засаг дарга Д.Сайнбилэг, Санхүүгийн албан дарга Д.Азжаргал, нягтлан бодогч Д.Баттөр нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

БИЧСЭН:  
 АУДИТОР  Б.НАРАНГЭРЭЛ  
 6417143544  
 БН-А00067 9007423

ЗӨВШӨӨРСӨН:  
 ЖАРГАЛАНТ СУМЫН ЗАСАГ ДАРГА.  
 Д.САЙНБИЛЭГ  
 САНХҮҮГИЙН АЛБАНЫ ДАРГА:  
 Д.АЗЖАРГАЛ  
 НЯГТЛАН БОДОГЧ:  
 Д.БАТТӨР

<sup>1</sup> Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА**

2018 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 15

Номгон

Г Зөрчил арилгуулах тухай 7

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Жаргалант сумын Сум хөгжүүлэх сангийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сум хөгжүүлэх сангийн 2017 оны орлого, зарлага, зээл авсан 45 иргэний зээлийн үлдэгдлийн мэдээллийг журамд заасан хугацаанд аймгийн Засаг даргад хүргүүлээгүйгээс Монгол банкны зээлийн мэдээллийн санд оруулах нөхцлийг бүрдүүлээгүй байна.

Энэ нь Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор баталсан "Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам"-ын 5.4-д " Сумын Засаг дарга сангийн орлого, зарлагын гүйцэтгэлийн тайланг... аймгийн Засаг даргад хүргүүлнэ" гэсэн заалтыг зөрчсөн байна

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.1.7-д "Хууль, тогтоомж зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх..." гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Сангаас олгосон хугацаа хэтэрсэн зээлүүдийн үлдэгдэл болон орлого, зарлагын гүйцэтгэлийн тайланг холбогдох байгууллагад мэдээлж зээлдэгчийн



мэдээллийг Монгол банкны зээлийн мэдээллийн санд оруулах нөхцлийг бүрдүүлэх.

2. Албан шаардлагын биелэлтийг 2018 оны 04 дугаар сарын 25-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Жаргалант сумын Засаг дарга Д.Сайнбилэг, Санхүүгийн албан дарга Д.Азжаргал, нягтлан бодогч Д.Баттөр нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ



АУДИТОР

БИЧСЭН:

Б.НАРАНГЭРЭЛ



ЗӨВШӨӨРСӨН:

ЖАРГАЛАНТ СУМЫН ЗАСАГ ДАРГА.

Д.САЙНБИЛЭГ

САХХҮҮГИЙН АЛБАНЫ ДАРГА:

*Handwritten signature of D. Azhargal*

Д.АЗЖАРГАЛ

НЯГТЛАН БОДОГЧ:

*Handwritten signature of D. Battor*

Д.БАТТӨР

<sup>1</sup> Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.